

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/204/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер: О.Амаржаргал

Утас: 70273463. Цахим хаяг: amarjargal@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл

Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

᠘ᠠᠳᠤᠰ - ᠠᠨ - ᠒5 № 4/10᠗  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Л.АЛТАНХУЯГ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангаар анхан шатны баримтаар нотлогдохгүй 10,213.7 мянган төгрөгийн гүйлгээг баримтжуулаагүй, 15,431.9 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа сонгон шалгаруулалт, үнийн харьцуулалт хийгээгүй гэрээ байгуулаагүй, бичгээр харилцаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 50 дугаар зүйлийн 50.1-д "Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих болон бусад үүрэгтэй оролцож байгаа төрийн албан хаагч дараах үүрэг хүлээнэ", 50.1.1-д "шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх", 50.1.2-т "төрийн ашиг сонирхлыг дээдлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" гэсэнтэй нийцээгүй, УСНББОУС-1 санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, толилуулга, иж бүрэн зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

᠒19᠙2᠐128

## **Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн эцэст зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийг дараагийн жилд зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 64,420.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### **Аудитын гол асуудал**

Алтанбулаг сумын эрүүл мэндийн төв нь тусгай зөвшөөрлөөр эргэлтийн эмийн сангаар дамжуулан эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг эрхлэн явуулдаг, эм борлуулсны орлого 80,614.3 мянган төгрөг цахим баримтад илүү шивэгдсэн байна.

Эргэлтийн эмийн сан нь байргын түрээсийн төлбөр, түрээсийн орлого төсөвт төвлөрүүлээгүй, төсвөөс байр ашиглалтын төлбөр, эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус хог, тээвэр шатахууныг зарцуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 1 удирдах, 15 гүйцэтгэх, 2 үйлчилгээний ажилтан нийт 20 орон тоо батлагдсанаас 16 бүтэц орон тоогоор ажилласан байна. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэргэжүүлэхээр төлөвлөснөөс 93,5 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээлэлийг хамруулаагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>73,911,919.53</u></b>	<b><u>116,285,259.69</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	24,660,086.51	64,420,461.77
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	24,660,086.51	64,420,461.77
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	24,660,086.51	64,420,461.77
31211	Төрийн сангийн харилцах	24,660,086.51	64,420,461.77
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	715,968.33	9,759,157.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	715,968.33	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	9,759,157.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	48,535,864.69	42,105,640.92
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	26,963,838.62	16,762,496.15
35110	Тусгай зориулалттай материал	807,855.00	807,855.00
35130	Эм боох материал	26,155,983.62	15,954,641.15
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	21,572,026.07	25,343,144.77
35410	Бичиг хэргийн материал	435,700.00	565,700.00
35420	Аж ахуйн материал	16,271,660.49	19,420,891.49
35430	Сэлбэг хэрэгсэл	4,825,200.00	5,315,250.00
35460	Хүнсний материал	39,465.58	41,303.28
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>549,131,383.02</u></b>	<b><u>1,368,444,649.56</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	549,131,383.02	1,368,444,649.56
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	538,057,383.02	1,349,978,649.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	330,805,084.00	1,124,269,588.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-42,999,499.34	-56,923,206.01
39203	Авто-тээврийн хэрэгсэл	158,221,679.00	158,221,679.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-59,496,152.24	-71,905,384.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	212,641,991.98	252,236,905.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	-83,215,518.32	-80,611,254.69
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,243,530.80	34,131,580.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,463,214.34	-11,502,898.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,578,400.00	2,578,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,147,903.52	-1,405,743.56
39217	Ном	888,985.00	888,985.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	11,074,000.00	18,466,000.00
39301	Програм хангамж	430,000.00	430,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-430,000.00	-430,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,074,000.00	18,466,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>623,043,302.55</u></b>	<b><u>1,484,729,909.25</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>623,043,302.55</u></b>	<b><u>1,484,729,909.25</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	623,043,302.55	1,484,729,909.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын	288,767,215.63	288,767,215.63

	сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн	288,767,215.63	288,767,215.63
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>213,343,043.80</b>	<b>1,075,243,125.53</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	213,343,043.80	213,556,518.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	861,686,606.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	120,933,043.12	120,719,568.09
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>623,043,302.55</b>	<b>1,484,729,909.25</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>610,371,091.21</b>	<b>1,556,873,035.01</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>69,546,241.21</b>	<b>890,285,908.77</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>69,546,241.21</b>	<b>890,285,908.77</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	51,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	51,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>540,824,850.00</b>	<b>666,587,126.24</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>250,000.00</b>	<b>9,759,157.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00	9,759,157.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>30,460,500.00</b>	<b>34,567,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,460,500.00	34,567,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>510,114,350.00</b>	<b>622,260,769.24</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	510,114,350.00	622,260,769.24
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>621,731,431.08</b>	<b>695,186,428.31</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>621,731,431.08</b>	<b>695,186,428.31</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>618,793,986.90</b>	<b>694,860,062.75</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>342,161,221.09</b>	<b>409,301,882.15</b>
210101	Үндсэн цалин	225,633,735.79	238,388,850.01
210102	Нэмэгдэл	94,743,154.98	134,473,175.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,546,997.35	7,025,000.00
210104	Урамшуулал	18,237,332.97	29,414,856.90
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>48,766,253.35</b>	<b>54,174,664.16</b>
210201	Тэтгэврийн даатгал	35,723,141.17	35,871,063.39
210202	Тэтгэмжийн даатгал	3,254,790.32	4,575,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,604,012.24	3,661,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	650,877.99	915,400.77
210205	Эрүүл мэндийн даатгал	6,533,431.63	9,151,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>27,362,848.00</b>	<b>32,940,834.44</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,464,400.00	6,423,146.44
210302	Түлш, халаалт	21,898,448.00	25,917,688.00

210303	Цэвэр, бохир ус	00.00	600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>34,058,993.67</b>	<b>35,070,840.00</b>
210401	Бичиг хэрэг	2,452,500.00	1,390,600.00
210402	Тээвэр, шатахуун	26,459,700.00	25,019,720.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	1,926,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	281,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	1,026,400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	4,246,793.67	5,427,020.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>87,376,869.67</b>	<b>89,439,990.54</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	73,197,699.40	75,272,968.24
210502	Хоол, хүнс	13,328,720.27	13,881,722.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	850,450.00	285,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>809,300.00</b>	<b>3,448,200.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	350,000.00
210604	Урсгал засвар	809,300.00	3,098,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,913,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	2,913,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>00.00</b>	<b>707,450.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	66,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	32,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	33,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>76,258,501.12</b>	<b>66,862,801.46</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,448,246.25	9,466,880.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,810,254.87	57,395,921.46
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,937,444.18</b>	<b>326,365.56</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>326,365.56</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	326,365.56
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,937,444.18</b>	<b>00.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,937,444.18	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-11,360,339.87</b>	<b>861,686,606.70</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-11,360,339.87</b>	<b>861,686,606.70</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>592,516,670.00</b>	<b>707,827,969.24</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>51,000,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>51,000,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	51,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	51,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>592,516,670.00</b>	<b>656,827,969.24</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>51,941,820.00</b>	<b>00.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,941,820.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>30,460,500.00</b>	<b>34,567,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,460,500.00	34,567,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>510,114,350.00</b>	<b>622,260,769.24</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	510,114,350.00	622,260,769.24
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>542,566,172.27</b>	<b>604,871,188.98</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>542,566,172.27</b>	<b>604,871,188.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>538,166,338.09</b>	<b>604,544,823.42</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>342,687,850.88</b>	<b>408,585,913.82</b>
210101	Үндсэн цалин	226,160,365.48	237,672,881.68
210102	Нэмэгдэл	94,743,155.08	134,473,175.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,546,997.35	7,025,000.00
210104	Урамшуулал	18,237,332.97	29,414,856.90
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>46,777,233.56</b>	<b>54,174,664.16</b>
210201	Тэтгэврийн даатгал	34,854,174.85	35,871,063.39
210202	Тэтгэмжийн даатгал	2,974,776.95	4,575,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,380,001.56	3,661,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	594,875.30	915,400.77
210205	Эрүүл мэндийн даатгал	5,973,404.90	9,151,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>27,362,848.00</b>	<b>32,940,834.44</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,464,400.00	6,423,146.44
210302	Түлш, халаалт	21,898,448.00	25,917,688.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	600,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,926,600.00</b>	<b>29,376,270.00</b>
210401	Бичиг хэрэг	2,566,900.00	1,520,600.00
210402	Тээвэр, шатахуун	24,860,100.00	24,041,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	1,926,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,599,600.00	707,440.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	1,180,850.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>63,582,109.40</b>	<b>56,011,311.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,272,509.40	40,271,400.00

210502	Хоол, хүнс	12,199,600.00	13,883,560.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,110,000.00	1,856,351.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,070,520.00</b>	<b>8,515,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	200,000.00	482,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500,000.00	4,444,900.00
210604	Урсгал засвар	4,370,520.00	3,588,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,913,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	2,913,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>00.00</b>	<b>707,450.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	66,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	32,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	33,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>18,759,176.25</b>	<b>11,319,080.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,759,176.25	11,319,080.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,399,834.18</b>	<b>326,365.56</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,462,390.00</b>	<b>00.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,462,390.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>326,365.56</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	326,365.56
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,937,444.18</b>	<b>00.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,937,444.18	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>49,950,497.73</b>	<b>102,956,780.26</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>28,787,000.00</b>	<b>63,196,405.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>28,787,000.00</b>	<b>63,196,405.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>28,787,000.00</b>	<b>63,196,405.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,787,000.00	63,196,405.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-28,787,000.00</b>	<b>-63,196,405.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>21,163,497.73</b>	<b>39,760,375.26</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,496,588.68</b>	<b>24,660,086.51</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>24,660,086.51</b>	<b>64,420,461.77</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	288,767,215.63	121,307,932.92	-89,760,379.01	320,314,769.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	374,889.80	374,889.80
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>288,767,215.63</b>	<b>121,307,932.92</b>	<b>-89,385,489.21</b>	320,689,659.34
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	234,555,538.40	234,555,538.40
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>288,767,215.63</b>	<b>120,933,043.12</b>	<b>213,343,043.80</b>	623,043,302.55
D01	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>288,767,215.63</b>	<b>120,933,043.12</b>	<b>213,343,043.80</b>	623,043,302.55
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	213,475.03	213,475.03
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>288,767,215.63</b>	<b>120,933,043.12</b>	<b>213,556,518.83</b>	623,256,777.58
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-213,475.03	00.00	-213,475.03
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	861,686,606.70	861,686,606.70
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>288,767,215.63</b>	<b>120,719,568.09</b>	<b>1,075,243,125.53</b>	1,484,729,909.25

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	24,660,086.51	(24,660,086.51)	
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	√ 736,503,400.00	√ 633,500,393.98	103,003,006.02	86.01
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	736,503,400.00	633,500,393.98	103,003,006.02	86.01
4	Бараа, үйлчилгээний зардал	736,503,400.00	633,500,393.98	103,003,006.02	86.01
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	492,770,500.00	408,585,913.82	84,184,586.18	82.92
6	Үндсэн цалин	323,413,600.00	237,672,881.68	85,740,718.32	73.49
7	Нэмэгдэл	106,949,100.00	134,473,175.24	(27,524,075.24)	125.74
8	Унаа, болон бусад нөхөн олговор	3,704,400.00	7,025,000.00	(3,320,600.00)	189.64
9	Урамшуулал	58,703,400.00	29,414,856.90	29,288,543.10	50.11
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,660,200.00	54,174,664.16	3,485,535.84	93.96
12	Тэтгэврийн даатгал	39,209,000.00	35,871,063.39	3,337,936.61	91.49
13	Тэтгэмжийн даатгал	4,612,000.00	4,575,200.00	36,800.00	99.20
14	ҮОМШӨ ний даатгал	3,690,700.00	3,661,100.00	29,600.00	99.20
15	Ажилгүйдлийн даатгал	922,800.00	915,400.77	7,399.23	99.20
16	Эрүүл мэндийн даатгал	9,225,700.00	9,151,900.00	73,800.00	99.20
22	Хангамж, бараа материалын зардал	31,097,200.00	29,376,270.00	1,720,930.00	94.47
23	Бичиг хэрэг	1,824,800.00	1,520,600.00	304,200.00	83.33
24	Тээвэр (шатахуун)	24,041,300.00	24,041,280.00	20.00	100.00
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,550,000.00	1,926,100.00	623,900.00	75.53
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,199,700.00	707,440.00	492,260.00	58.97
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,481,400.00	1,180,850.00	300,550.00	79.71
30	Нормативт зардал	59,078,300.00	56,011,311.00	3,066,989.00	94.81
31	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,271,400.00	40,271,400.00	-	100.00
32	Хоол, хүнс	15,431,900.00	13,883,560.00	1,548,340.00	89.97
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	3,375,000.00	1,856,351.00	1,518,649.00	55.00
34	Эд хогшил худалдан авах	75,078,700.00	69,893,900.00	5,184,800.00	93.09
35	Багаж, техник, хэрэгсэл	58,000,000.00	57,932,700.00	67,300.00	99.88
36	Тавилга	9,500,000.00	4,623,000.00	4,877,000.00	48.66
37	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	5,124,700.00	5,049,900.00	74,800.00	98.54
38	Урсгал засвар	2,454,000.00	2,288,300.00	165,700.00	93.25
39	Томилолт, зочны зардал	3,328,300.00	2,913,400.00	414,900.00	87.53
41	Дотоод албан томилолт	3,328,300.00	2,913,400.00	414,900.00	87.53
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,055,000.00	707,450.00	347,550.00	67.06
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	632,000.00	576,000.00	56,000.00	91.14

46	Даатгалын үйлчилгээ	234,500.00	66,450.00	168,050.00	28.34
47	Тээврийн хэрэгслийн татвар	40,000.00	32,000.00	8,000.00	80.00
48	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00	-	100.00
50	Газрын төлбөр	18,500.00	-	18,500.00	-
51	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	97,000.00	-	97,000.00	-
53	Бараа үйлчилгээний бусад зардал	16,435,200.00	11,837,485.00	4,597,715.00	72.03
54	Бараа үйлчилгээний бусад зардал	16,435,200.00	11,837,485.00	4,597,715.00	72.03
97	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	673,260,769.24	673,260,769.24	-	100.00
106	<b>НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	622,260,769.24	622,260,769.24	-	100.00
108	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	622,260,769.24	622,260,769.24	-	100.00
110	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	51,000,000.00	51,000,000.00	-	100.00
112	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,000,000.00	51,000,000.00	-	100.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	24,660,086.51	(24,660,086.51)	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	64,420,461.77	(64,420,461.77)	-
133	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	20.00	20.00	-	100.00
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	-	100.00
136	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	34,567,200.00	34,240,834.44
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	34,567,200.00	34,240,834.44
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	34,567,200.00	34,240,834.44
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	33,267,200.00	32,940,834.44
210301	Гэрэл, цахилгаан	6,557,200.00	6,423,146.44
210302	Түлш, халаалт	26,110,000.00	25,917,688.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,300,000.00	1,300,000.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	1,300,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	34,567,200.00	34,567,200.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	34,567,200.00	34,567,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	34,567,200.00	34,567,200.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сумын хүн амд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх анхны байгууллага Бор-өндөр гэдэг газар 2 гэрт, 1 бага эмч, 1 сувилагч, 1 үйлчлэгчтэй үүсгэн байгуулагдсан. 1958 оноос Алтанбулагийн төв шилжин суурьшиж хүний бага эмчийн салбар үйл ажиллагаа явуулсан. 1974 оноос 15 ортой эмнэлгийн зориулалттай байр ашиглалтад орж, их эмчийн салбар бий болсон.

Тус байгууллага нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сумын хүн амд чанартай, хүртээмжтэй хүргэн, эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээ явуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Алтанбулаг сумын эрүүл мэндийн төв нь зорилгоо “Хүн амд чанартай хүртээмжтэй тэгш эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх” гэж тодорхойлсон байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Алтанбулаг сумын эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д “Хот суурийн газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” үзүүлдэг эрүүл мэндийн сайдын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн чиг үүргийг эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх, сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх гэж тодорхойлсон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд доорх өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Эрүүл мэндийн тухай хууль
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль
- ✓ Зөвшөөрлийн тухай хууль
- ✓ Эм, эмнэлгийн хэрэглэлийн тухай хууль
- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ
- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 01 дүгээр сарын А/05 тушаалаар 4 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг томилогдон ажиллаж байна. Дотоод хяналтаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж үр нөлөөтэй ажиллаж байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузел сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 862,934.61 мянган төгрөгөөр буюу 238,5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	24,660.09	64,420.46	39,760.38
Авлага	715.97	9,759.16	9,043.19
Урьдчилгаа			-
Бараа материал	48,535.86	42,105.64	(6,430.22)
Үндсэн хөрөнгө	549,131.38	1,369,692.65	820,561.27
<b>Нийт хөрөнгө</b>	<b>623,043.30</b>	<b>1,485,977.91</b>	<b>862,934.61</b>
Өр төлбөр			-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	288,767.22	288,767.22	-
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>623,043.30</b>	<b>1,485,977.91</b>	

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн данс 39,760.3 мянган төгрөгийн өөрчлөлттэй байгаа нь хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн эцэст зарцуулагдаагүйтэй холбоотой мөнгөн хөрөнгийн данс 64,420.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, өмнөх оноос 39,760.38 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Авлагын дансны үлдэгдэл 9,043.19 мянган төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн нийгмийн даатгалын газраас авлага үүссэн байна.

Бараа материал 6,430.22 мянган төгрөгөөр буурсан нь ашиглахгүй байгаа бараа материалыг акталсан.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 820,561.27 мянган төгрөгөөр өссөн нь ЭМТ-ийн өргөтгөлийн барилга шинээр ашиглалтад орж хөрөнгөнд бүртгэсэн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 358,499.1 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 153,463.5 мянган төгрөг, нийт зарлагыг 511,962.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 660,843.4 мянган төгрөг, зардлыг 148,880.8 мянган төгрөгөөр өсгөж 660,843.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор өссөн байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсвийг 148,880.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 358,499.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 153,463.5 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 436,040.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 161,560.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 558,103.9 мянган төгрөг буюу 116,7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 85,638.2 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн нь жилийн эцэст 64,420.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80302- Нэг иргэнд ноогдох нормативаар	478,069.90	436,040.28	42,029.62	91.21
2	81603-Үндсэн тусламж үйлчилгээ	182,773.50	161,560.49	21,213.01	88.39
3	83601-Нэмэлт олон улсын байгууллагаас олгосон	1,000.00	1,000.00	-	100.00
4	83603 -Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	74,660.00	74,396.40	263.60	99.65

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хоол хүнсэнд 15,431.9 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс 13,883.5 мянган төгрөг зарцуулсан, тээвэр шатахуунд 24,041.4 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс 24,041.3 мянган төгрөг зарцуулсан, эм боох материал 40,271.4 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс 40,271.4 мянган төгрөг зарцуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ийн аудитор Б.Дашням, Шинжээч Д.Энх-Амгалан, Ө.Бат-Оюун нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 11/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн

байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн 623,043.3 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 9,345,6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,009.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг төвийн захирал албан томилолтоор ажилласан зардлаа авахгүй байх зэргээр зардлыг хэмнэх арга хэмжээг авч ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлэх 159 мэдээллээс 151 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 2 мэдээлэл, 6 мэдээлэл байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг мөрдөн ажиллаагүй байна.

2. Шилэн дансны мэдээллээр цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 43,217.2 мянган төгрөгөөр өссөн дүнгээр зөрүүтэй мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

4.4.2.1 Мөнгөн хөрөнгийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 80,614.3 мянган 4.4.2.1 Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 80,614.3 мянган төгрөгийн цахим баримт илүү шивэгдсэн зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

4.4.2.2 Төв аймгийн эрүүл мэндийн газраас эмийн сангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон, Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн улсын бүртгэлийн гэрчилгээ дүрэмд эрхлэх үйл ажиллагаагаар бүртгэгдээгүй байгаа нь зөвшөөрлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн нийтлэг шаардлагад 1.1-д “иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх”, 1.2-т “хуульд заасан бол мэргэжил, мэргэшлийн шалгалтад тэнцсэн, зохих дүгнэлт гаргуулсан байх”, 1.3-д “татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх”, 2-т “Зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэг хүлээнэ”, 2.1-д “хуульд заасан баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх”, 2.2-т “тухайн үйл ажиллагааг эрхлэх хуулиар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах”, 2.3-д “хуулиар хориглосон, эсхүл хязгаарласан тохиолдолд зөвшөөрөлд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхгүй байх”, 2.4-д “хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг байнга эрхлэн явуулах”, 2.5-д “зөвшөөрлийг эрх бүхий этгээдээс авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ тухай татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх”, 2.6-д, 3 дугаар бүлгийн 3.2.2-т заасан хуульд заасан зарчмыг баримтлах, 2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд зөвшөөрөл олгох гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

4.4.2.3 Алтанбулаг сумын эрүүл мэндийн төв нь тусгай зөвшөөрлөөр эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг давхар эрхлэн явуулдаг, эргэлтийн эмийн сан нэртэй эрхзүйн чадамжгүй, сан нь үйл ажиллагаа явуулахдаа байрны түрээсийн төлбөр төлдөггүй түрээсийн орлого төсөвт төвлөрүүлээгүй, төсвөөс байр ашиглалтын төлбөр, эмийн сангийн эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус, хог, тээвэр, шатахууны төлбөрийг төлж байгаа нь Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 20 дугаар зүйлд захирлын эрх үүрэгт 20.5-д “Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол

учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна”, 21 дүгээр зүйлд “ Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх

4.4.2.4 Улсын бүртгэлийн гэрчилгээнд хөрөнгийн хэмжээ 40,219.0 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 288,767.2 мянган төгрөг буюу 248,548.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Санхүүгийн тайланд тусгагдсан ажил гүйлгээ буюу үйл явдал, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн байх гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээллийн алдааг үнэн зөв бүртгэх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Татварын тухай, Төсвийн тухай, Зөвшөөрлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Улсын бүртгэлийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар анхан шатны и-баримтын бүрдэл, Засгийн газар оролцоо сангийн бүртгэл, цалинтай холбоотой бүртгэл, шилэн дансны мэдээлэл, бичиг хэрэг хөтлөлт, өглөгийн данстай холбоотой бүртгэл, эмийн эргэлтийн сантай холбоотой нийт 6 зөвлөмж хүргүүлснээс 1 зөвлөмж хэрэгжүүлэн ажилласан, 5 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	236.0	1	236.0	100.0
Албан шаардлага	1	575,955.3	0	-	-
Зөвлөмж	3	2,150.0	2	-	66.7
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>578,341.3</b>	<b>3</b>	<b>236.0</b>	<b>166.6667</b>

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 578,341.3 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс 236.0 төгрөгийн актыг бүрэн барагдуулж, 575,955.3 мянган төгрөгийн албан шаардлага хэрэгжээгүй, 2,150.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс цахим баримтыг худалдан авалтыг төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зөвлөмжийг хэрэгжүүлэн

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эмийн эргэлтийн сан нь байрны түрээсийн төлбөр төлдөггүй, хувь хүн иргэдэд олгосон цахим баримтыг байгууллагын регистрээр шивдэг, ашиглалтын зардал төлөхгүй байгаа асуудлыг авч үзэх, норматив зардлын гүйцэтгэлийг давтан хянах, худалдан авалт хийхдээ үнийн харьцуулалт хийдэг эсэх, албан бичгээр харилцдаг эсэхийг авч үзэх.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 27,921.3 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс, 11,006.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, дахин давтахгүй байх 2 албан шаардлага хүргүүлж, 16,915.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлээ.

#### 5.2 Албан шаардлага

5.2.1 Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримтгүй 10,213.7 мянган төгрөгөөр дутуу хөтөлж баримтжуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй"; 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Татварын цахим тайлангийн системээр зам ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, газрын төлбөр, авто тээврийн хэрэгслийн төлбөр нийт 792.2 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй"; 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Цалингийн зардлын данстай холбоотой**

##### Илрүүлэлт:

Цалингийн тооцооны хүснэгтээр олгохоор тооцсон цалин 423,894.4 мянган төгрөг, нийгмийн даатгалд тайлагнасан дүн 422,411.0 мянган төгрөг нийгмийн даатгалд 1,483.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тооцооллын алдаагүй, үнэн зөв хураангуйлан бүртгэж байх.

#### **2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой**

##### Илрүүлэлт:

Байгууллагын 36 нэр төрлийн 36,822.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үлдэх өртөггүй анхны өртгөө нөхсөн байгаа нь хөрөнгийн бүртгэлийг бодит үнэ цэнээр бүртгэж тайлагнаагүй, тооллого тооцооны үр дүнг хэлэлцээгүй, чанар байдлыг тодорхойлоогүй, ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийн жагсаалт, мэдээллийн тодруулга тайлан бэлтгэж тайлагнаагүй байгаа нь СТОУС-13 стандартын 6.12-д “Бодит үнэ цэнэ гэж зах зээлд оролцогчдын хоорондох цэгцтэй ажил гүйлгээгээр хэмжилтийн өдөр хөрөнгийг борлуулснаар хүлээн авах эсвэл өр төлбөрийг барагдуулснаар төлөх үнийн дүн юм”, 6.13-д “Бодит үнэ цэнд зах зээлд оролцогчид буюу тухайн аж ахуйн нэгж нэвтрэх боломжтой зах зээлд оролцогчдын хэтийн төлөв тусгагддаг. Эдийн засгийн ашиг тусын төлөө хамгийн сайн үйл ажиллагаа эрхэлдэг бол хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо тэдний ашиглаж болох ижил төстэй таамаглалыг ашиглан, тэдгээр хөрөнгө өр төлбөрийг хэмждэг” гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн бүртгэлийг бодит үнэ цэнээр, үнэн зөв бүртгэж, тайлагнадаг байх зөвлөмж хүргүүлэв.

#### **3. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой**

##### Илрүүлэлт:

Бараа материал худалдан авалт хийх, бэлтгэхдээ үнийн харьцуулалт хийгээгүй, хэдэн төгрөгөөр ямар төрлийн бараа үйлчилгээ авах нь тодорхойгүй, гэрээ байгуулан гэрээний үүргийн хяналтыг хэрэгжүүлээгүй, сумын Засаг даргын тамгын газраас худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг гэсэн хэдий ч хүчин төгөлдөр баримтаар нотлогдохгүй, ил тод байх, мэдээлэл авах эрхийг ханган ажиллаагүй, албан тушаалын давуу байдал бий болсон, шударга өрсөлдөх боломжийг бүрдүүлээгүй, төрийн ашиг сонирхлыг дээдлэн ажиллаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 50 дугаар зүйлийн 50.1-д “Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих болон бусад үүрэгтэй оролцож байгаа төрийн албан хаагч дараах үүрэг хүлээнэ”, 50.1.1-д “шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх”, 50.1.2-т “төрийн ашиг сонирхлыг дээдлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэнтэй нийцээгүй, УСНББОУС-1 тайлангийн эрх ба үүрэг, толилуулга, иж бүрэн зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь. Худалдан авалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу авдаг байх, үнийн харьцуулалт хийдэг байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримтгүй	1	10,213.7			1	10,213.7						
Зам ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, газрын төлбөр, авто тээврийн хэрэгслийн төлбөр төлөөгүй	1	792.3			1	792.3						
Цалингийн тооцоо, нийгмийн даатгалын тооцоо 1,483.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	1,483.4					1	1,483.4				
Байгууллагын 36 нэр төрлийн үндсэн хөрөнгө үлдэх өртөггүй анхны өртгөө нөхсөн.	1						1					
Бараа материал худалдан авалт хийх, бэлтгэхдээ үнийн харьцуулалт хийгээгүй.	1	15,431.9					1	15,431.9				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>27,921.3</b>			<b>2</b>	<b>11,006.0</b>	<b>2</b>	<b>16,915.3</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцорсон 2 мэдээлэл, мэдээлээгүй 6 мэдээлэл байна.	1				1			
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 43,217.2 мянган төгрөг өссөн дүнгээр зөрүүтэй мэдээлсэн байна.	1	43,217.2			1	43,217.2		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>43,217.2</b>			<b>1</b>	<b>43,217.4</b>		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримт 80,614.3 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байна.	1	80,614.4					1	80,614.4
Хөрөнгийн хэмжээ 40,219.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	248,548.0					1	248,548.0
Эм худалдан борлуулах эмийн сангийн үйлчилгээг давхар эрхлэн явуулдаг	1						1	
Түрээсийн орлого ашиглалтын төлбөр, эмийн сангийн эм зүйчийн цалин хөлс, шимтгэл, гэрэл цахилгаан, дулаан, ус, хог, тээвэр, шатахууны төлбөрийг зориулалт бусаар зарцуулсан	1						1	
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>329,162.4</b>					<b>4</b>	<b>329,162.4</b>
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>372,379.6</b>			<b>2</b>	<b>43,217.4</b>	<b>4</b>	<b>329,162.4</b>



ТӨВ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 29-14570576-ТӨА-2024/204/НА СТА-ТШС  
Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар анхан шатны цахим баримтгүй 10,213.7 мянган төгрөгөөр дутуу хөтөлж баримтжуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5. Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." заалтуудыг хэрэгжүүлж ажиллах; гэсэнтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн<sup>2</sup> **ШААРДАХ** нь:

<sup>2</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040116

1. Цахим төлбөрийн баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>3</sup> ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн дарга Л.Алтанхуяг, нягтлан бодогч Н.Оюунчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/Н.ОЮУНГЭРЭЛ/

---

<sup>3</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582



ТӨВ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 30-4570516-ТӨА-2024/

Зуунмод

2024/03/12 ТӨА-ТМЦ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 43,217,200 /дөчин гурван сая хоёр зуун арван долоон мянга хоёр зуун/ төгрөг өссөн дүнгээр зөрүүтэй мэдээлсэн, хугацаа хоцорсон 2 мэдээлэл, мэдээлээгүй 6 мэдээлэл байршуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод, бүрэн байршуулах зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>5</sup> ирүүлэх;

<sup>5</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040125

2.Цаашид алдаа, зөрчлийг<sup>6</sup> давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн дарга Л.Алтанхуяг, нягтлан бодогч Н.Оюунчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/

<sup>6</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582



ТӨВ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 35-14310516-ТВА-2024/2024/НА-СТА-ТМЗ

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар зам ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, газрын төлбөр, авто тээврийн хэрэгслийн төлбөр 792.2 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй гарсан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зам ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, газрын төлбөр, авто тээврийн хэрэгслийн төлбөр 792.2 мянган төгрөгийн татвар төлөх биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн дарга Л.Алтанхуяг, нягтлан бодогч Н.Оюунчимэг нарт даалгав.

<sup>1</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040121

АЛБАН<sup>2</sup> ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/



---

<sup>2</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582